БАТЛАВ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН

ЗАСАГ ДАРГА З.ОЮУНДУЛАМ

АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 12 сарын 04-ны өдөр Бүрд сум

ТШ-ын код, нэр	ӨВАБҮСЗДТГ/20250101005, Ариун цэврийн байгууламжтай болох
Үндэслэл	Сумын ИТХ-ын 2025 оны 07 сарын 30-ны өдрийн 05/01 тогтоолын гуравдугаар хавсралт
Байршил	Өвөрхангай аймгийн Бүрд сумын 5-р баг, Онгон
Захиалагч	Бүрд сумын Засаг даргын тамгын газар
Эх үүсвэр	Сумын Орон нутгийн хөгжлийн сан
Төсөвт өртөг	250 000 000 /Хоёр зуун тавин сая/ төгрөг
Барилгын зураг төсөл, төсөв	Ариун цэврийн байгууламжийн барилгын ажил, дагалдах ажил болон тоног төхөөрөмжийн хамтаар 250 000 000 /Хоёр зуун тавин сая/ төгрөгөөс илүүгүй байхаар төсөвлөнө.
Зорилго ач холбогдол	Сумын иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ахуйн эрүүл мэндийг сайжруулах
Тавигдах шаардлага	Монгол улсын халуун ус, сауны стандарт хангасан шинэлэг технологийг нэвтрүүлсэн өнгө үзэмж бат бөх байдлыг хангасан байна.
Архитектор төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал	**<u>Ерөнхий шаардлага:</u>** Халуун усны барилга нь мэргэжлийн байгууллагын баталсан зураг төслийн дагуу, батлагдсан төсөвт багтаан баригдаж, "Нийтийн халуун усны үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5163:2002" стандартын шаардлага хангасан байна. Нийтийн халуун усны барилга нь усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, агааржуулалтын систем, халаалтын системтэй, шаардагдах гадна шугам сүлжээнд холбогдсон байна. Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй байх, салхины 25м/с хурдад тэсвэртэй, орчны уур амьсгалын байдал, үйлчилгээний барилга нь байгаль цаг уурын бүсчлэлийн нөхцөлд тохируулан -40 хэмээс +35 хэмээр тооцож зургийг боловсруулж батлуулна. Гал түймрийн аюулаас хамгаалах арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. **<u>Үйлчилгээний барилгын үзүүлэлт:</u>** Овор хэмжээ: Барилга нь 5 метрээс багагүй өндөртэй, нийтийн халуун усны ерөнхий шаардлагыг хангасан, 80м.кв-аас багагүй 120м.кв-аас ихгүй талбайтай. • Цахилгаан хангамж техникийн нөхцөлөөр • Цэвэр усан хангамжийг бие даасан байдлаар шийдвэрлэх • Бохирын бие даасан шийдэлтэй, септик танк эсвэл эколос цэвэрлэх байгууламжтай дүйцэхүйц байх, халуун усны нийт хэрэгцээтэй хүн амын тоотой уялдуулан төлөвлөх • Хог, хаягдлыг цуглуулах, зайлуулах шийдэлтэй. • Ашиглалт/цаг уурын нөхцөл: Үйлчилгээний барилга нь байгаль цаг уурын бүсчлэлийн нөхцөлд тохируулан -40 хэмээс +35 хэмээр тооцсон байна. • Гадна тохижилт: Хашаатай, автомашин болон явган зорчигчийн орц гарцыг шийдсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шаттай, талбайн нь хатуу хучилттай байх, гэрэлтүүлэгтэй байх • Холбоо, дохиоллын системтэй байх

<table>
<tr><td></td><td>• Бусад холбогдох тоног төхөөрөмж</td></tr>
<tr><td>Оффис, ариун цэврийн болон ажилчдын өрөөний тавилга хэрэгсэл</td><td>Үйлчилгээний хүчин чадалтай уялдуулан талбайг тооцож тохижуулна.</td></tr>
<tr><td>Зураг төсөл боловсруулахад ашиглах материал</td><td><u>Монгол Улсын хуулиуд:</u>
• Барилгын тухай хууль
• “Нийтийн халуун усны үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5163:2002“ стандарт
• Бусад хууль тогтоомж
<u>Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:</u>
<u>Норм норматив, стандарт:</u>
• Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм ба дүрэм /БНбД 21.02.02/, /БНбД 31-02-02/ бусад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх
• 1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил /БД 11-106-08/;
• Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт
• Онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжтой авто машин нэвтрэх боломжийг хангаж төлөвлөх</td></tr>
<tr><td>Барилгын үндсэн бүтээц</td><td>
<table>
<tr><td colspan="2">Инженер геологийн судалгаа</td><td>Инженер геологийн судалгааны дүгнэлтийг шинээр хийнэ.</td></tr>
<tr><td rowspan="4">Даацын үндсэн бүтээц</td><td>Суурь:</td><td>Цутгамал төмөр бетон бүтээцтэй төлөвлөх ба барилгын норм ба дүрмийн хүрээнд зураг төслөөр төлөвлөнө.</td></tr>
<tr><td rowspan="2">Гадна хана:</td><td>Ханын 2.4м өндөр тоосго, өргөт бүтээц эсвэл бетон бүтээцтэй.</td></tr>
<tr><td>Эрдэс хөвөн дулаалга түүнтэй дүйцэхүйц, зураг төслөөр норм, дүрмийн хүрээнд төлөвлөнө.</td></tr>
<tr><td>Хучилт:</td><td>Төмөр бетон, зураг төслөөр норм, дүрмийн хүрээнд төлөвлөнө.</td></tr>
<tr><td colspan="2">Дээвэр:</td><td>Шувуун нуруун дээвэртэй төлөвлөнө.</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр</td><td>Дулаан хангамж: Төвийн төвлөрсөн дулааны шугамын эх үүсвэр/Техникийн нөхцөлөөр/
Цахилгаан хангамж: Төвийн төвлөрсөн цахилгаан хангамжийн эх үүсвэр/Техникийн нөхцөлөөр/
Цэвэр усан хангамж: Цэвэр усан хангамжийг бие даасан байдлаар буюу гүний худгаар шийдвэрлэх, эсвэл боломжит ойр байрлах цэвэр усны гүнийн худгаас эх үүсвэрээ шийдвэрлэх
Бохир усан хангамж, ариутгах татуурга: Бохир усан хангамж, ариутгах татуургыг бие даасан байдлаар төлөвлөх ба нийт бохир усны хэрэглээнд тулгуурлан бага оврын цэвэрлэх байгууламж/Септик/ эсвэл Эколос цэвэрлэх байгууламж, түүнтэй дүйцэхүйц шийдэл</td></tr>
<tr><td>Зураг төсөв</td><td>Тендерт оролцогч өгөгдсөн даалгаврын дагуу зураг, төсвөө боловсруулж ирүүлнэ.</td></tr>
<tr><td>Галын аюулгүй байдал</td><td>Төлөвлөж буй барилга байгууламжийн зай хэмжээг галын болон бусад холбогдох норм дүрмийн дагуу төлөвлөх</td></tr>
<tr><td>Байгаль орчны үнэлгээ, нөхцөл</td><td>Шаардлагагүй.</td></tr>
<tr><td>Эдийн засгийн тооцоо</td><td>Төсвийг эстиматор про программаар хийсэн байна.</td></tr>
</table>

	• Хяналтын камераар тоноглогдсон байх • Агааржуулалтын системтэй • Дотор гэрэлтүүлэх ус нэвтрэхгүй, уур цан цохиж хөлрөхгүй байх • Барилгын дотор хананд усал дусал, уур үүсдэггүй, цан цохидоггүй, дулаанаас хамаарсан агшилт, тэлэлт явагддаггүй байх • Барилгын дотор хана, шал, тоног төхөөрөмж нь цэвэрлэгээ, үйлчилгээ хийхэд хялбар, гөлгөр, тэгш гадаргуутай байх • Шал хана нь ус нэвтэрдэггүй, цэвэрлэж халдваргүйжүүлэхэд тохиромжтой, хүчил, шүлт, халуун усанд тэсвэртэй, хагарч, цуурахгүй, халтирч, гулсахгүй материалаар зай завсаргүй, нягт хийгдсэн байх бөгөөд ус чөлөөтэй урсаж, бохир зайлуулах хоолой руу орж байхаар тооцсон байна. • Барилгын хана хоорондын болон хана, шалны хоорондын булан нь нүх сүвгүй, сайтар битүүмжилсэн, цэвэрлэгээг хялбаршуулах зорилгоор хана шалны уулзварыг 2.5 см радиусаар хагас дугуйрсан эсвэл 45-60 радиусын налуу гадаргуутай хийсэн байх • Тааз нь тоос шороо, уур, цан хуримтлагдахааргүй, будаг шохой нь хуурч унахааргүй, хөгц мөөгөнцөр үүсэхээргүй, цэвэрлэхэд хялбар байдлаар төлөвлөсөн байх • Цонх нь битүүмжлэл сайтай, нягт хаагддаг, гадна төмөр хамгаалалттай, нисдэг шавж орохоос урьдчилан сэргийлж торон хаалттай байна. • Бохир ус зайлуулах суваг нь цэвэр, бат бөх, ямар ч нөхцөлд ус чөлөөтэй урсахаар байна. <u>Барилгын байрны үндсэн өрөө:</u> Халуун усны өрөө • Том хүний душны өрөө 6 ширхэг • Сауны өрөө 2 ширхэг • Үйлчлэгчийн өрөө 1 ширхэг • Үсчин гоо сайхны өрөө 1 ширхэг Ариун цэврийн өрөө • Суултуур 6 ширхэг • Хүүхдийн суултуур 2 ширхэг • Том хүний босоо тосгуур 3 ширхэг • Хүүхдийн босоо тосгуур 1 ширхэг • Том хүний гар угаах угаалтуур 4-6 ширхэг • Хүүхдийн гар угаах угаалтуур 2 ширхэг • Техникийн өрөө /Цэвэр усны нөөцийн сав, цахилгааны шийд зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл байрлана./ Эдгээр өрөө тасалгааг стандартын шаардлагын дагуу тохижуулсан байна.
Тоног төхөөрөмж	• Бойлуур /ялтсан 50 литрээс дээш 6 ширхэг, 6 шүршүүр, саун, ариун цэврийн өрөө, үсчин гоо сайхны өрөө/ • Шүршүүр • Холигч • Суултуур • Мэдрэгчтэй босоо тосгуур • Хатаагч • Гар хатаагч-4ш • Хувцасны шүүгээ, өлгүүр • Сауны өрөөний тоног төхөөрөмж /тогоор халдаг зуух, сандал гэх мэт/

Онцгой нөхцөл	• Монгол Улсын хууль, Барилгын норм ба дүрмийг баримталсан байх • Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, техникийн аюулгүй ажиллагаанд тавигдах олон улсын болон Монгол Улсын холбогдох стандартын шаардлага, норм, дүрмийг баримталсан байх

БОЛОВСРУУЛСАН:
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА Г.АНХТӨР

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.МӨНХСАРУУЛ